

ТӨВДИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВ

*Ш.Догмийчойдон**

Төвдийн Өөртөө Засах Орон (ТӨЗО) нь БНХАУ-ын баруун өмнөд хэсэгт Балба, Энэтхэг улсуудтай хиллэн, Хималай, Куньлунь уулсуудаар хүрээлэгдэж Хөх нуур-Төвдийн өндөрлөгт оршдог. Далайн төвшнөөс дээш дунджаар 4000 метрийн өндөрт орших тул “Дэлхийн дээвэр” хэмээн алдаршжээ.

ТӨЗО-ы нийслэл нь Лхас хот. Тус мужид Хятад дахь бусад мужуудаас хүн амын нягтрал хамгийн бага байдаг. Хятадын статистикийн 1990 оны мэдээгээр Төвд нь 2.196 сая хүн амтай байсан бол 1998 онд хүн амын тоо 2.45 сая болтлоо өсч, түүний дотор төвд үндэстэн 2.36 сая (96.33%), хан үндэстэн 67 мянга (2.73%), 23 мянга нь бусад үндэстэн байв. 1999 он гэхэд 2.56 сая хүн амтай болж хүн амын төрөлт 2.32%, нас баралт 0.74%, хүн амын цэвэр өсөлт 1.58 хувь болжээ. Тус мужийн хүн амын 96%-ийг төвдүүд эзэлдэг ба хан, хуй (хотон), монгол, монба, лхоба гэх зэрэг үндэстэн амьдардаг.

БНХАУ-ын Сычуань, Ганьсу, Хөх нуур, Юньнань, Шинжаан, Төвд зэрэг мужуудад төвд үндэстэн оршин суудаг бөгөөд нийтдээ 4593072 төвд үндэстэн оршин суудаг байна.

ТӨЗО нь засаг захиргааны хувьд 7 тойрог, тойргийн зэрэглэлийн 1 хот, 72 сян (хошуу), 1 сяний зэрэглэлийн хот зэрэгт хуваагддаг байна. Лхас, Шигазе, Чамдо, Нагчү, Шаньнан, Нинчи зэрэг томоохон хотуудтай.

Тус муж нь хром, боракс (аж үйлдвэрт хэрэглэгддэг натрийн төрлийн химийн чухал элемент. Угаалгын нунтаг, саван хийх, шил шаазан өнгөлөх, нэхмэл болон арьс шир боловсруулах, цаас үйлдвэрлэхэд хэрэглэгддэг.), хар төмөрлөг, лити, алт, зэс, гөлтгөнө, шохой гэх мэт ашигт малтмалаар баялаг хийгээд БНХАУ дахь хамгийн их боракс-ийн нөөц Төвдөд байдаг байна. Түүнчлэн Хятад дахь модны нөөцөөр хамгийн баян газрын нэг. Голлох үр тарианы ургамал гэвэл уулархаг нутгийн арвай, улаан буудай, буурцаг, вандуй. Мөн хятад, төвд эмийн найрлагад ордог олон төрлийн ургамал ургадаг байна.

*Ш.Догмийчойдон - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

Энэ муж нь дэд бүтэц сул хөгжсөн бөгөөд БНХАУ дахь төмөр замгүй цорын ганц нутаг юм. БНХАУ-ын “Баруун бүс нутгийг хөгжүүлэх хөтөлбөр”-т ТӨЗО-ы дэд бүтцийг хөгжүүлэх асуудал орсон. Уг хөтөлбөрийн хүрээнд Хөх нуурын Голмуд хотоос ТӨЗО-ы Лхас хот хүртэл төмөр зам тавьж байна.

Төвд рүү тээвэрлэлтийг гол төлөв засмал замаар хүргэдэг бөгөөд нийт засмал замын урт нь 22 мян.км, Сычуань, Хөх нуур, Шинжаан, Юньнань мужуудыг холбож улмаар Лхас хотыг Балбын Катманду хоттой холбодог. Одоо Пинанаас Хөх нуурын Синин хүртэл зам тавьж буй бөгөөд Ланьжоу-Синингийн хурдны авто зам 2000 гаруй метрийн өндөрт баригдаж байна. 2005 оны эцэс гэхэд нийт 27 мянган км урт, орон нутгийн 70-90% нь шинэ замтай болох ажээ.

ТӨЗО-ы Гонгар, Банда нисэх онгоцны буудал нь Чэнду, Чунцин, Бээжин, Сиань, Хөх нуур, Балбын Катманду зэрэг 25 чиглэлд нислэг хийдэг. 2000 оны 4-р сараас Шанхай руу шинэ чиглэл нээгдсэн бөгөөд Лхасаас-Шанхайн чиглэлд 4 цаг орчим нисдэг юм байна.

2000 онд Төвдийн 100 хүн тутамд 4,7 телефон утас ногдож байв. 2001 оны 5-р сард Лхас-Алигийн шилэн кабелийг тавьж Төвдийн бүх нутгийг холбожээ. Энгийн телефон утсан холбооны үйлчилгээ тус мужийн Лхас, Шигазе, Нинчи, Чамдо, Али гэх мэт газарт байдаг бөгөөд 2000 оны 9-р сард ойролцоогоор энгийн телефон утас хэрэглэгч 57 мянгал хүрчээ. 2000 онд ийм телефон утасны орлого 35 сая юань болж, 1999 оны мөн үеийнхээс 93% илүү болжээ. Тус мужид 1998 оны 3-р сараас интернетийн үйлчилгээг эхлүүлж Лхас хотод одоогоор интернетийн үйлчилгээ эрхэлдэг 100 гаруй газар ажиллаж байна.

Тус муж нь далайн түвшнээс дээш нэлээд өндөрт оршдог тул нарны эрчим хүчний нөөц баялаг ихтэй юм. Одоогоор тус мужид нарны эрчим хүчний 20 гаруй жижиг, дунд оврын цахилгаан станц ажилладаг бөгөөд Хятадын хамгийн том геотермийн цахилгаан станцын нэг Янбажины цахилгаан станц нь 25 мянган квт/цаг хүчин чадалтай. Мөн Ямжог Юмцо нуурын дэргэд 112,500 квт/цаг хүчин чадалтай усан цахилгаан станц, Чаглуны цахилгаан станц байгуулж байна.

Төвдийн өөр нэг чухал асуудал бол Лхас-Гонгар-Зэтан, Лхас-Шигазе, Лхас-Нинчи-Чамдо зэрэг хотуудын хооронд нефть дамжуулах хоолойн байгууламжийн зураг төслийг 2001-2006 оны хооронд хийж гүйцэтгэж, тус байгууламжийг барих ажлыг 2005-2020 онд эхлэж, нефть дамжуулах хоолойг 2006-2030 оны хооронд тус тус дэс дараалан ашиглалтанд оруулахаар төлөвлөжээ.

Байгал орчны экологийг хамгаалах талаар 5 гол бүс байгуулахаар төлөвлөж хөрс боловсруулах гол бүсэд Дорнод Төвдийн гурван голын хөндий (Нузянь, Ланчанзянь, Жиншазянь), Нян голын хөндий. Ярлун Занбо голын дунд хөндийг тус тус багтаажээ. Хүрээлэн байгаа орчны экологийг хамгаалах үндсэн 4 тойрогт Чагяаб, Чамдо, Мангам, Зоган зэргийг багтааж энэ салбарт 1.1 тэрбум юаний хөрөнгө оруулалттай 19 төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

ТӨЗО нь Хонгонг, АНУ, Өмнөд Африк, Бразил зэрэг орнуудад нэхмэл, ноос, эмийн ургамал, хивс зэрэг хөдөө аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүн голлон экспортлодог. 2000 онд Төвдийн экспорт 20%-иар нэмэгдэж 100 сая ам.долларт хүрчээ.

Мөн Орос, БНСУ, Япон, Австрали, Балба зэрэг орнуудаас голлон барилгын материал, механик, электрон бараа, химийн бүтээгдэхүүн импортлодог. 1999 оны байдлаар импорт нь 50% буурч 40 сая ам.доллар болсон байна.

Тус мужид Хонгконг, Балба, Англи, АНУ зэрэг орнуудаас цахилгаан эрчим хүч, үйлдвэрийн тоног төхөөрөмж, үйлчилгээ, хүрээлэн буй орчин, тээвэр, хүнсний бүтээгдэхүүн боловсруулах зэрэг салбарт голлон хөрөнгө оруулдаг ажээ. АНУ, Япон, Герман, Малайз, Балба зэрэг орнуудын хөрөнгө оруулалттай 50 гаруй үйлдвэр, аж ахуйн газар ажиллаж байна. Хятадын төв, баруун бүс нутгийг хөгжүүлэхийн тулд Төрийн Зөвлөлөөс Хятад дахь гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрт татварын хөнгөлөлт олгож байна. Энэ хөнгөлөлт нь гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрийн татварыг 3 жил хөнгөлөх ба чөлөөлөх юм. Хэрэв экспортын 70%-д хүрвэл татварын хэмжээ 10% хүртэл буурах ажээ.

2001 оноос 100 жижиг хотод гол замыг тавих засах, хөдөлгөөнийг хурдасгах, хотжилтыг сайжруулахаар төлөвлөж байна. Түүнчлэн аж үйлдвэр, ХАА, төвд эм, харилцаа холбоо, эрдэс түүхий эд, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд анхаарч байна. ТӨЗО-ыг газар нутгийн байдал, орон нутгийн онцлог, ашигт малтмал, түүхий эдийн нөөцөд тулгуурлан дунд, баруун, өмнөд, дорнод ба хойд гэсэн эдийн засаг, техникийн хөгжлийн гол 5 бүсэд хуваан хөгжүүлэхээр төлөвлөжээ. Үүнд:

- Дунд бүс - Лхас, Шигазе, Шаньнанийг хамардаг. Голлон өндөр чанартай хөдөө аж ахуй, уул уурхайн үйлдвэр, эрчим хүч, дэд бүтцийг хөгжүүлэх

- Дорнод бүс - Нинчи, Чамдо хамардаг. Төвдийн ойн хамгийн их нөөц баялаг энэ бүсэд байдаг учир модны үйлдвэрлэлийг гол төлөв хөгжүүлэх
- Өмнөд бүс - Халуун бүсийн тариалан хөгжүүлэх
- Баруун бүс - 13 хошуугаар (сянь) 5 оронтой хиллэдэг тул хилийн худалдаа хөгжүүлэх
- Хойт бүс - Нагчү, Алиг хамардаг. Голлон мал аж ахуй, нефть, байгалийн хий олборлох болон уул уурхайн үйлдвэрлэлийг хөгжүүлэх юм байна.

Томоохон хотуудын эдийн засгийн үзүүлэлт

Хотууд	Хүн ам ('000)	Дотоодын нийт бүтээгдэхүүн (тэрбум юань)	Жижиглэн худалдаа (тэрбум юань)
Лхас	397.9 (+0.5%)	3.3 (+15.0%)	1842.7 (-3.0%)
Шигазе	629.7 (+0.9%)	1.5 (-15.8%)	662.2 (+24.7%)
Чамдо	557 (+1.1%)	1.5 (+12.1%)	320.2 (-2.4%)
Нагчү	356.5 (+1.9%)	0.9 (+28.8%)	460.6 (+48.4%)
Шаньнан	316 (+0.6%)	0.7 (+16.1%)	254.7 (+15.6%)
Нинчи	147.1 (+0.8%)	0.9 (+15.5%)	148.5 (+23.6%)

Тайлбар: () жилийн өсөлт

Эх сурвалж: Tibet Statistical Yearbook, 2000

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

§ <http://www.tdctrade.com/mktprof/china/mptib.htm>

§ <http://www.tibetinfo.com//>

§ Tibet Statistical Yearbook, 2000

§ The World Book Encyclopedia. USA 1995